

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ-2024

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах						
Үндсэн чиг үүргийн нэр: Биеийн тамирын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эруул мэндээ хамгаалах, сайжруулах/ нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүргэмжтэй болгох						
Биеийн тамир спортын тухай хуулийн 4.1.2 дахь заалт						
Зорилт-1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүргэмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ	арга хэмжээ-1 Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлэх;	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар) сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ хувиар тооцно	Суурь үзүүлэлт 2023 онд 47.9 хувь	2021 онд 54.5 хувьд, 2022 онд 56 хувьд, 2023 онд 57.5 хувьд, 2024 онд 59 хувьд хүргэх	2024 онд 17 сум, 69 байгууллагын 14758 иргэнээс сорил авсан байна. Хамрагдсан иргэдийг үнэлүүлэхэд: 2210-А, 3373-В, 1536-С үнэлгээ авсан байна. Аймгийн нийт иргэдийн 13.5 хувь буюу 14758 сорилд хамрагдсан байна. Сумууд болон төрийн байгууллагуудын нийт ажилчдын 20 хувиас бие бялдрын сорилыг авч нэгдсэн санд бүртгүүлсэн. Иргэдийн 30 гаруй хувь нь илүүдэл жинтэй гарч байна.	90
арга хэмжээ-2 Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлэх	Сумын биеийн тамирын арга зүйчийн тоог 17 болгосон байна.	Аймгийн бүх суманд биеийн тамирын арга зүйч байхгүй	2023 онд 17 суманд орон тооны бус арга зүйчтэй болно. 2022-2024 онуудад орон тооны биеийн тамирын арга зүйчтэй болох	Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар бүлэг 8.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Ховд аймгийн 17 сумаас Эрдэнэбүрэн, Манхан, Мянгад, Жаргалант, Булган, Мөст суманд орон тооны арга зүйчтэй болсон. Бусад сумууд хавсаргах байдлаар орон тооны бус арга зүйчийг ажиллуулж байна. Сумдад арга зүйчийн орон тоонд мэргэжлийн боловсон хүчинг нээлттэй зарлаж сонгон шалгаруулж ажиллуулах чиглэлийг аймгийн Засаг даргаар хүргүүлэн ажиллаж байна. Сумын биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах, тухайн сумын биеийн тамир спортын судалгааг үнэн зөв тодорхойлсноор биеийн тамир, спорт хөгжих боломж бүрдэж	70	

	арга хэмжээ-3 Биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн технологийн бааз, платформ бий болгож хэрэгжүүлэх	Мэдээллийн сангийн үйл ажиллагаа эхэлж, 3 ажил, үйлчилгээ цахимаар үзүүлдэг болсон байна.	-	2021 онд Мэдээллийн сангийн үйл ажиллагаа эхлүүлсэн байна. 2024 онд Спортын тэмцээн, наадмын ажил, үйлчилгээг цахимаар үзүүлдэг болсон байна	Мэдээллийн цахим санг хөгжүүлэх мэдээ мэдээлэл байршуулах арга хэмжээг тогтмол зохион байгуулаа. sport.gov.mn болон байгууллагын цахим мэдээллийн санд 90 чиглэлээр 64 арга хэмжээний мэдээ, мэдээлэл байршуулсан. Мэдээлэл байршуулснаар ард иргэд мэдээлэл авч үйлчлүүлэх иргэд спортоор хичээллэх хүүхдийн тоо 20 хувиар нэмэгдлээ.	100
	арга хэмжээ-4 Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх	Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан 23 спортын холбоодын үйл ажиллагаатай холбоотой эх өгөгдөл байршсан байна.	-	2022-2023 онд 12 спортын холбоо 2023-2024 онд 11 спортын холбооны мэдээллийг бүрдүүлэх	Цахим санд байршуулах мэдээ мэдээлэл цуглуулах бэлтгэх сан бүрдүүлэх талаар спортын холбоодод албан бичиг хүргүүлэн уулзалт зохион байгуулсан. Мэдээ мэдээллийг 90 чиглэлээр Khovd@sport.gov.mn хаяг дээр байршуулж эхлээд байна.	90
Зорилт-2. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт зам талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина, засварлана.	арга хэмжээ-1 Аймгийн төвд байрлах 2000 хүний суудалтай төв цэнгэлдэх хүрээлэнг их засварт оруулах	Цэнгэлдэх хүрээлэн ашиглалтад орсон байна.	2021 он ТЭЗҮ боловсруулж байна	2021-2022 онд засвар хийж ашиглалтанд оруулах	Стадионы их засварыг 2021 оны 6 сарын 20-с 8 сарын 3 ны хооронд зураг төсвийн дагуу хийж дуусган хүлээн авсан.	100
	арга хэмжээ-2 Улс, бүсийн чанартай тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах	Зохион байгуулсан тэмцээний тоо	2023 онд Улсын аварга шалгаруулах тэмцээн 2-ыг зохион байгуулсан байна.	2024 онд улс, бүсийн тэмцээн нэгийг зохион байгуулах	2024 он Өндөр уулын авиралтын альпинат-2024, Чөлөөт бөх, Байт харвааны өсвөрийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдсан. Нийтдээ 1160 шилдэг тамирчин оролцсон байна. Орон нутагт бус, Улсын аварга шалгаруулах тэмцээн зохиогдсоноор материаллаг бааз шинээр бий болж тухайн спортоор хичээллэгчдийн тоо 5-10 хувиар эрс нэмэгдсэн байна. Шилдэг тамирчдыг даган дуурайх спортоор хичээллэх амжилт гаргах зэрэг ач холбогдолтой байна.	100

<p>арга хэмжээ-3 Аймгийн Спортын төв ордонд урсгал засвар, бага зааланд их засвар хийх ажлыг эхлүүлэх</p>	<p>ТЭЗҮ тулгуурлан санхүүжилтийг эх үүсвэрийг шийдвэрлэсэн байна.</p>	<p>2022-2023 он</p>	<p>2022-2023 онд засвар хийж ашиглалтанд оруулах</p>	<p>Байгууллагын үйл ажиллагааг явуулахад таатай орчинг бүрдүүлэх зорилгоор байгууллагын зарим өрөө бэлтгэлийн заал, саун, 00-ын өрөөг иж бүрэн засварлах ажлын төндөр хуулийн дагуу зөрлөгдөж Зөвлөн тэмүүлэх ХХК шалгарч засварын ажил 2023 оны 06 сарын 12-с 08 сарын 05-ны хооронд хийгдэж хүлээн авлаа. Байгууллагын үйл ажиллагааг явуулахад таатай орчинг бүрдүүлэх зорилгоор спорт цогцолборын гадна пасатыг 188 сая төгрөгөөр засварлахаар орон нутгийн төсвөөс ИТХ-аар баталсан. Завсар хийх зураг төсөв шинээр хийгдэж төсөвт өртөг нэмэгдэж 720 сая төгрөгөөр хийлгэхээр тодотголоор оруулан батлуулж засварын төндөр зарлагдаж гэрээ хийгдэж засварын ажил эхлэж байна.</p>	<p>100</p>
<p>арга хэмжээ-4 Цэцэг, Дарви, Зэрэг, Эрдэнэбүрэн сум, Жаргалант сумын Бугат, Хайрхан багийн спорт заалыг ашиглалтанд оруулах</p>	<p>Цэцэг, Дарви, Зэрэг, Эрдэнэбүрэн сум, Жаргалант сумын Бугат, Хайрхан багийн спорт заал шинээр барина</p>	<p>Барилга угсралтын ажил явагдаж байна</p>	<p>2022-2023 онд ашиглалтанд оруулах</p>	<p>Алтай, Зэрэг, Цэцэг, Дарви сум, Жаргалант сумын Бугат, Хайрхан багт спорт заал баригдаж байна. 2023 оны 9 сард Зэрэг сумын заалыг ашиглалтад хүлээн авлаа. 2024 онд спортын заал Алтай сум-30%, Дарви-50%, Цэцэг-60%-ийн Зэрэг-100%, Жаргалант сумын Хайрхан, Бугат-100%-ийн гүйцэтгэлтэй хүлээн авсан байна. Дээрх заалуудын гүйцэтгэл дээр хяналт тавин ажиллаж байна.</p>	<p>70</p>
<p>арга хэмжээ-5 Жаргалант сумын Рашаант, Цамбагарав, Алагтолгой, Хайрхан багуудад стандартын шаардлага хангасан биеийн тамир, спорт тоглоомын талбай байгуулах</p>	<p>Жаргалант сумын Рашаант, Цамбагарав, Алагтолгой, Хайрхан багуудад стандартын шаардлага хангасан биеийн тамир, спорт тоглоомын талбай байгуулна</p>	<p>Нэг хэв маягийн зураг төсөвтэй, газрын асуудал шийдвэрлэгдсэн</p>	<p>2021-2023 онд ашиглалтанд оруулах</p>	<p>Жаргалант сумын Рашаант, Цамбагарав, Алагтолгой, Хайрхан багуудад биеийн тамир, спорт тоглоомын талбайнууд зураг төсвийн дагуу хийгдэж дууссан байна.</p>	<p>100</p>
<p>арга хэмжээ-6 Аймгийн төвд гүйлт, алхалтын зам шинээр байгуулах</p>	<p>ТЭЗҮ тулгуурлан санхүүжилтийг эх үүсвэрийг шийдвэрлэсэн байна.</p>	<p>Байгуулах газар чиглэл шийдвэрлэгдсэн</p>	<p>2021-2023 онд ашиглалтанд оруулах</p>	<p>Бага голын гүүрнээс их голын гүүр хооронд алхалт гүйлтийн зам зураг төсвийн дагуу 300 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хийгдэж дууссан байна. Улсын комисс хүлээн авч ашиглалтад орсон байна.</p>	<p>100</p>

<p>Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах</p> <p>Үнэсэн чиг үүргийн нэр: Спортын сургалт-дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, өсвөрийн шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг бүс, улс, олон улс, тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх</p> <p>Биеийн тамир спортын тухай хуулийн 18.5, 8.1.5 дахь заалт</p>						
Зорилт-3	Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах	арга хэмжээ-1 Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийн залгамж халааг сайжруулах, шигшээ багийн спортын төрлийг нэмэгдүүлэх	8 спортын төрлөөр шигшээ багийг байгуулсан байна.	2022 онд 2 спортын төрлөөр шигшээ багийг нэмж байгуулсан байна. 2024 онд 2 спортын төрлөөр шигшээ багийг нэмж байгуулсан байна.	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийн 8 дасгалжуулагчийн 2023, 2024 оны цалин 113 сая төгрөгийг батлуулан цалинжуулж ажиллаа. 2025 онд дасгалжуулагчийн цалинд 275 сая төгрөг төсөвт суулган батлуулж авсан.	100
	арга хэмжээ-2 Спортын амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад мөнгөн шагнал олгох, олимпын наадам, дэлхийн аварга, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчин, дасгалжуулагчдад олгосон мөнгөн шагналын дүн, тоо	Олимпын наадам, дэлхийн аварга, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчин, дасгалжуулагчдад олгосон мөнгөн шагналын дүн, тоо	68 тамирчин, 8 дасгалжуулагчд ад 13,630,000 төгрөг олгосон байна	Аймгаас ИТХ-ын тэргүүлэгчдээс баталсан Урамшууллын журмын дагуу тамирчин, дасгалжуулагчдад мөнгөн урамшуулал олгоно.	Ховд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 11 сарын 3-ны өдрийн 67 дугаар тогтоолоор шинэчлэн боловсруулж батлууллаа. 2022 онд 47 сая төгрөгийн урамшууллыг олгосон 2023 оны тамирчин дасгалжуулагчдын урамшууллын 57,9 сая төгрөгийг дансаар олгосон байна. 2024 онд 64 сая төгрөгийн урамшууллыг тамирчин, дасгалжуулагч багш нарт дансаар олгож гарын бэлэг батламж гардууллаа.	100
	арга хэмжээ-3 Сургалт-дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах	Аймгийн хэмжээнд 10 дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна	Мэргэшүүлэх сургалтын эрх зүйн орчин бүрдсэн, сургалт зохион байгуулах сургууль, багш сонгогдсон.	2022 онд 8, 2023 онд 6 багш дасгалжуулагчдыг сургалтад хамруулсан байна	Байгууллагын дасгалжуулагчид ЗГТАБТСУХ-с зохион байгуулсан цахим сургалтууд мөн удирдлагын академиас зохион байгуулсан төрийн албан хаагчийн сургалтуудад дасгалжуулагч нар бүрэн хамрагдсан. /Цахим сургалт 28/	100
	арга хэмжээ-4 Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн спортын төрөл, тамирчин сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах	Аймгийн Засаг даргын дэргэдэх шигшээ багийг нийт 8 спортын төрлөөр бүрдүүлсэн байна.	Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн спортын төрөл, тамирчин, дасгалжуулагчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.	2023 онд өсвөрийн шигшээ багийн 8 спортын төрөл, тамирчин, дасгалжуулагчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.	Засаг даргын дэргэд спортын 8 төрлөөр шигшээ баг байгуулж 685 тамирчин бэлтгэл сургуулилтаа тогтмол хийж байна. Шигшээ багийн дасгалжуулагчдын цалинг орон нутгийн төсөвт тусуулан 113 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс шийдвэрлэн олгож байна. Шигшээ багийн 8 дасгалжуулагчдыг сонгон шалгаруулах ажлыг зохион	100

<p>арга хэмжээ-5 Хүүхэд, залуучуудын спортын авьяасыг илрүүлж шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх хүрээнд аймгийн хэмжээнд спортын наадам, аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг жил тутам зохион явуулах, зохион байгуулалтыг оновчтой болгох</p>	<p>Хүүхдийн спортын бага наадам, Залуучуудын спортын их наадмыг зохион байгуулах</p>	<p>Спортын наадмыг зохион байгуулсан</p>	<p>2 жил тутамд тус бүр зохион байгуулсан байна.</p>	<p>байгуулах, бичиг баримтыг бүрдүүлэн шалгалтын бэлтгэл ажлыг хангаж журмын дагуу 10 сард шигшээ багийн дасгалжуулагчдыг Чөлөөт бөх, Жүдо бөх, Ширээний теннис, Үндэсний бөх, Сагсан бөмбөг, Волейбол, Хөлбөмбөг, Байт харвааны төрлүүдээр сонгон шалгаруулан авч ажиллуулаад байна. 2025 онд дасгалжуулагч нарын цалинд 275 сая төгрөгийг төсөвт суулгалаа. Тэмцээн уралдааны зардлуудыг шийдвэрлэснээр тамирчдын амжилт өсч 2024 онд 372 медаль хүртсэн амжилттай байна...</p>
				<p>Оюутан залуучуудыг спортоор хичээллэх идэвхи санаачлага, бие бялдрын боловсрол олгох, оюун ухаан сэтгэн бодох чадварыг нь хөгжүүлэх, урам зоригийг нь нэмэгдүүлэх, спортын ур чадварыг нь дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авьяастай өсөх ирээдүйтэй тамирчдыг нээн илрүүлж спортоор хичээллэгчдийн тоог өсгөх, баг хамт олны багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "Найрсаг Эко Ховд оюутан залуучуудыг спортын Их наадам"-ыг 2023 оны 08 дугаар сарын 08-11-ны өдрүүдэд Ховд хотноо зохион байгууллаа. Тус наадамд Сагсан бөмбөг, Волейбол, Хөл бөмбөг, Шатар, Даам, Ширээний теннис, Уулын дугуй, Буухиа зэрэг спортын найман төрлөөр Ховд аймгийн 16 сум, Жаргалант сумын 12 багийн нийт 18-35 насны 1100 гаруй тамирчин оролцож хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн байна. 2024 онд аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 3 насны ангилалд 23 амжилттай зохион байгуулсан байна.</p>

<p>арга хэмжээ-6 Шинэ тугам хөгжиж буй спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Улсын хэмжээнд шинэ тугам хөгжиж буй спортын төрлийг хамрах хүрээг 25%-д хүргэх</p>	<p>Эрх зүйн орчин бүрдсэн, спортын төрлийн хамрах хүрээний судалгаа хийгдсэн</p>	<p>Байт сурын холбоог шинээр байгуулж үйл ажиллагааг эхлүүлэн бэлтгэл сургалт тогтмол хийгдэж байна. Байт сурын холбоо өөрсдийн хөрөнгөөр шинэ бэлтгэлийн заал барих санаачлага гарган ажиллаж байна. Аймаг орон нутгаас газрын асуудлыг шийдвэрлэж өглөө. 2024 онд ширээний шагайн спортыг шинээр хөгжүүлж анхны тэмцээн уралдааныг зохион байгуулж хэрэглэл материал, ширээ зэргийг стандартын дагуу хийж ашиглаж эхэлсэн. Дардасын спортыг хөгжүүлэхээр хэрэглэл материалыг авч нийтийн биеийн тамирын болон бусад спортын арга хэмжээний хөтөлбөрт тусган тэмцээн уралдаан зохион байгуулан хөгжүүлж байна</p>	<p>100</p>
<p>арга хэмжээ-7 Өвлийн спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Өвлийн спортын хөгжлийг тогтмолжуулах, хэрэглэл материалыг нэмэгдүүлэх</p>	<p>Эрх зүйн орчин бүрдсэн, спортын төрлийн хамрах хүрээний судалгаа хийгдсэн</p>	<p>Өвлийн спортыг хөгжүүлэх чиглэлээр Ховд аймагт хувийн хэвшлийн тэшүүрийн 2 талбай үйл ажиллагаа явуулж давхардсан тоогоор 1000 гаруй иргэд хүүхэд хамрагдаж байнгын үйлчлүүлдэг. Өвлийн спортын төрөлд “Мөнгөлөг шагшурга-2024” цас мөсний баярын /40.000 хүн оролцлоо/ хүрээнд мөсөн шагайн харваа, урианхай сурын харвааг бүсийн хэмжээнд уламжлал болгон зохион байгууллаа. Урианхай сурын харвааг брэнд болгохоор зорин олон улсын чанартай уралдаан тэмцээн зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймагт зохион байгуулагдаг олон улсын чанартай өвлийн наадамд тэшүүрийн төрлөөр 10 тамирчин амжилттай оролцсон.</p>	<p>100</p>
<p>арга хэмжээ-8 Биеийн тамир, спортын ажил үйлчилгээний хүн амд үзүүлэх нэр төрлийг багийн спортын төрлөөр</p>	<p>Багийн спортын төрлийг нэмэгдүүлэх, хэрэглэл материалаар хангах</p>	<p>Эрх зүйн орчин бүрдсэн, спортын төрлийн хамрах хүрээний</p>	<p>Волейбол, Хөлбөмбөг, Сагсан бөмбөг, ширээний теннисний спортын төрлүүдээр Ховд аймгийн хэмжээнд 61 секц дугуйланд 4800 гаруй өсвөр үеийн хүүхдүүд</p>	<p>100</p>

<p>нэмэгдүүлж, орон нутагт хамрах хүрээг тэлэх</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, дэмжлэг үзүүлэх, хэрэглэл материалаар хангах</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын үйл ажиллагааг нэмэгдүүлэх</p>	<p>Судалгаа хийгдсэн</p>	<p>хичээллэж байна. Багийн спортоор хүүхдүүд олноор хичээллэж эхэлснээр бус, улсад гаргах амжилт өсч дээд лигт Ховд аймгийн 20 тамирчин оролцон тоглож байна. Өндөр түвшний тамирчид олноор төрөн гарч байна. 2024 онд багийн спортоор хичээллэх хүүхдийн тоо 10 хувиар нэмэгдсэн. Тэмцээн уралдааны тоо 1 дахин нэмэгдсэн байна.</p>	<p>100</p>
<p>арга хэмжээ-9 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, дэмжлэг үзүүлэх, хэрэглэл материалаар хангах</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ширээний теннис, сагсан бөмбөг, хөнгөн атлетик, волейбол, жүдо бөхийн төрлүүдээр 30 гаруй иргэн тогтмол хичээллэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сарын аяны хүрээнд спортын 8 арга хэмжээг 200 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмцээн уралдаан тогтмол зохион байгуулж, зааланд тоглох хувиар гарган тогтмол тоглуулж байна.</p>	<p>Эрх зүйн орчин бүрдсэн, спортын төрлийн хамрах хүрээний судалгаа хийгдсэн</p>	<p>2021 онд 5 % 2022 онд 15 % 2023 онд 20 % 2024 онд 25 % хүргэсэн байна.</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ширээний теннис, сагсан бөмбөг, хөнгөн атлетик, волейбол, жүдо бөхийн төрлүүдээр 30 гаруй иргэн тогтмол хичээллэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сарын аяны хүрээнд спортын 8 арга хэмжээг 200 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэмцээн уралдаан тогтмол зохион байгуулж, зааланд тоглох хувиар гарган тогтмол тоглуулж байна.</p>	<p>100</p>
<p>арга хэмжээ-10 Ахмад настны спортын үйл ажиллагаанд хамруулах, дэмжлэг үзүүлэх, хэрэглэл материалаар хангах</p>	<p>Ахмад настны иргэдийг спортын үйл ажиллагааг нэмэгдүүлэх</p>	<p>Эрх зүйн орчин бүрдсэн, спортын төрлийн хамрах хүрээний судалгаа хийгдсэн</p>	<p>2022 онд 5 % 2024 онд 10 % хүргэсэн байна.</p>	<p>“Цаг гаргаа” аяны хүрээнд ахмадуудыг өглөөний алхалт, хийн дасгал, шугаман бүжгийг Ард аюушийн талбай болон Спортын ордонд тогтмол хийлгэж хэвшсэн байна. 120 гаруй ахмад тогтмол хийн дасгал, шугаман бүжиг хийж өглөөний алхалтанд хамрагдаж байна. Ахмадын сарын аяны хүрээнд Ховд хотын Ахмадуудын дунд спортог зүүл ахмад өдөрлөгийг амжилттай зохион байгуулж сорил, эрүүл мэндийн үзлэг, ширээний шагай, хийн дасгал, 32 тоот дасгал, олс таталт, буухиа зэрэг арга хэмжээг зохион байгуулж 300 гаруй ахмадууд оролцсон.</p>	<p>100</p>

Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах

Үндсэн чиг үүргийн нэр: Төрийн байгууллагын нийтлэг чиг үүрэг
Биеийн тамир спортын тухай хуулийн 10.1.1 дэх заалт

<p>Зорилт-4. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах</p>	<p>арга хэмжээ-1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжүүлэн, тайланг хууль, журамд заасан хугацаанд харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх</p>	<p>Тухай жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр</p>	<p>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир спортын улсын хорооны дарга, аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллаа. Гүйцэтгэлийн тайлангийн биелэлт 92.0 хувьтай</p>	<p>100</p>
<p>арга хэмжээ-2 Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагнах, салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох</p>	<p>Тухай жилийн салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээгээр</p>	<p>Биеийн тамир спортын төлөвлөгөөг мөрдөгдөх хууль тогтоомж, журмыг хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	<p>100</p>	<p>100</p>
<p>арга хэмжээ-3 Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах</p>	<p>Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хувь, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан ажилтны тоо</p>	<p>Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан ажилтны тоо</p>	<p>Төрийн албан хаагчийн нийгмийн боловсруулалт хангах төлөвлөгөөг батлуулсан 6 ажлын төлөвлөн 100 хувьтай хэрэгжүүлж ажиллаа.</p>	<p>100</p>
<p>Зорилт-5. Биеийн тамир, спортын салбар гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх</p>	<p>арга хэмжээ-1 Биеийн тамир, спортын чиглэлээр гадаад улс орнуудын байгууллагуудтай хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах, хэрэгжилтийг хангуулах</p>	<p>Биеийн тамир, спортын чиглэлээр гадаад байгууллагуудтай хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах</p>	<p>БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймагтай өвлийн спортыг хөгжүүлэхээр хамтын ажиллагааны гэрээ байгуулсан, ОХУ-ын Алтай мужийн Алтайски районтой бөх, волейболын спортыг хөгжүүлэх, хамтарсан бэлтгэл, тэмцээн уралдаан зохиох зэрэг чиглэлээр хамтран ажиллахаар гэрээ байгуулан ажиллаж байна.</p>	<p>100</p>
<p>арга хэмжээ-2 Хөрш улс орнуудад дасгалжуулагч, тамирчны тамирчны хамтарсан бэлтгэл хийх</p>	<p>2-3 хөрш улс орнуудад дасгалжуулагч, тамирчны хамтарсан бэлтгэл хийх</p>	<p>Хятад, ОХУ-ын тамирчидтай хамтарсан бэлтгэл хийнэ.</p>	<p>БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймагт зохион байгуулагдаж олон улсын чанартай өвлийн наадамд тэшүүрийн төрлөөр 10 тамирчин оролцохоор 7 хоногийн хамтарсан бэлтгэлд хамрагдаж тэмцээнд амжилттай оролцсон.</p>	<p>100</p>

<p>Зорилт-6. Биеийн тамир, спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж, дүгнэлтээр хангах, хяналт тавих</p>	<p>арга хэмжээ-1 Биеийн тамир, спортын салбарын байгууллагын үйл ажиллагаанд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулж, зөвлөмж, дүгнэлтээр хангах, хяналт тавих</p>	<p>Спортын клуб, холбоодын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, дүгнэлтээр хангасан</p>	<p>2021 онд 8 спортын холбоо, клуб, 2022 онд 8 спортын холбоо, 2023 онд 8 спортын холбоо, 2024 онд 17 сумын спортын үйл ажиллагаанд хяналт тавьж зөвлөмж, дүгнэлтээр хангах</p>	<p>Спортын 8 холбооны үйл ажиллагаатай танилцаж зөвлөмж өгч арга зүйгээр ханган ажиллаа.</p> <p>90</p>
<p>Зорилт-7. Биеийн тамир, спортын салбарын хэмжээнд дотоод аудитын тогтолцоог бэхжүүлэн сайжруулах</p>	<p>арга хэмжээ-1 Байгууллагын эрсдэлд суурилсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит хийнэ.</p>	<p>Эрсдэлд суурилсан төлөвлөгөөт аудит, хяналт шалгалтыг 2 удаа байгууллагад хийнэ</p>	<p>2021 онд 1 2024 онд 1</p>	<p>Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир спортын Улсын хорооны мөргөжилтэн 4 сард байгууллага дээр ажиллаж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээ. Жилийн графика төрийн аудитаар шалгуулж зөрчилгүй дүгнүүлсэн.</p> <p>90</p>
<p>Нийт үнэлгээ</p>				<p>96.2</p>

Биеийн тамир спортын газрын стратеги төлөвлөгөөнд 27 ажил төлөвлөснөөс жилийн байдлаар 100 хувийн биелэлттэй -21, 90 хувийн биелэлттэй -4, 70 хувийн биелэлттэй -2 арга хэмжээ байна. Дундаж үнэлгээгээр хэрэгжилт жилийн байдлаар 96,2 % байна.

Төлөвлөгөө тайлагнасан:
Биеийн тамир спортын газрын дарга

Төсвийн Шууд захирагч
М.Түмэндэмбэрэл



2024.12.10